



## Агуулга

|                                                                                                                |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....                                                                             | 2  |
| 1.1. Төслийн талаарх мэдээлэл .....                                                                            | 2  |
| 1.2. Төслийн байршил.....                                                                                      | 2  |
| 1.3. Төслийн хүчин чадал .....                                                                                 | 3  |
| ХОЁР.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН<br>ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... | 8  |
| ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>.....                                           | 11 |
| ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....                                                                                 | 11 |
| ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                             | 12 |
| ДҮГНЭЛТ .....                                                                                                  | 17 |

## Хүснэгтийн жагсаалт

|                                                                                                                               |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....                                                                               | 2  |
| Хүснэгт № 2 Төслийн талбайн солбицол .....                                                                                    | 2  |
| Хүснэгт № 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....                                                        | 12 |
| Хүснэгт № 4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө .....                                            | 13 |
| Хүснэгт № 5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....                                                                          | 14 |
| Хүснэгт № 6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....                                                                      | 15 |
| Хүснэгт № 7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага<br>зохион байгуулалтын төлөвлөгөө..... | 16 |
| Хүснэгт № 8 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад<br>тайлагнах хуваарь .....                | 16 |
| Хүснэгт № 9 БОМТ-ний нийт зардал .....                                                                                        | 17 |

## Зургийн жагсаалт

|                                                                                   |    |
|-----------------------------------------------------------------------------------|----|
| Зураг № 1 Төслийн талбайн байршлын зураг .....                                    | 3  |
| Зураг № 2 Төслийн талбайн агаар сансрын зураг .....                               | 4  |
| Зураг № 3 Ус цэвэршүүлэх үйл явцын дараалал.....                                  | 6  |
| Зураг № 4 Цэвэрлэх байгууламж .....                                               | 7  |
| Зураг № 5 Ариун цэврийн өрөө, дүш.....                                            | 7  |
| Зураг № 6 Агаарын температур болон хур тунадасны олон жилийн түүхэн өгөгдөл ..... | 9  |
| Зураг № 7 Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураг .....                         | 10 |



## НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн талаарх мэдээлэл

#### Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


| №  | Үзүүлэлтүүд             |                                                 |
|----|-------------------------|-------------------------------------------------|
| 1  | Аж ахуйн нэгжийн нэр    | “Чингисхааны хүрээ” ХХК                         |
| 2  | Улсын бүртгэлийн дугаар | 9011362095                                      |
| 3  | Төслийн нэр             | “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбор |
| 4  | Төслийн байршил         | Нийслэл/Хот/<br>Аймаг                           |
| 5  |                         | Сум/Дүүрэг                                      |
| 6  |                         | Баг/Хороо                                       |
| 7  | Төсөл                   | Аймаг/Хот                                       |
| 8  | хэрэгжүүлэгчийн         | Сум/Дүүрэг                                      |
| 9  | хаяг                    | Баг/Хороо                                       |
| 10 | Захирлын хаяг           | Нэр                                             |
| 11 |                         | Гар утас                                        |

### 1.2. Төслийн байршил

“Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбор нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 8-р хорооны нутагт Богдхан уулын ДЦГ-ын Жаргалантын аманд оршдог. Гэр буудал болон гэр ресторан нь нийт 8 га талбайг эзэлдэг.

#### Хүснэгт № 2 Төслийн талбайн солбицол

| №  | Уртраг |       |        | Өргөрөг |       |        |
|----|--------|-------|--------|---------|-------|--------|
|    | Градус | Минут | Секунд | Градус  | Минут | Секунд |
| 1  | 106    | 49    | 5.11   | 47      | 48    | 38.81  |
| 2  | 106    | 49    | 4.77   | 47      | 48    | 37.23  |
| 3  | 106    | 49    | 7.08   | 47      | 48    | 36.06  |
| 4  | 106    | 49    | 10.13  | 47      | 48    | 35.50  |
| 5  | 106    | 49    | 11.02  | 47      | 48    | 31.92  |
| 6  | 106    | 49    | 4.64   | 47      | 48    | 30.85  |
| 7  | 106    | 49    | 6.46   | 47      | 48    | 26.55  |
| 8  | 106    | 49    | 4.72   | 47      | 48    | 26.22  |
| 9  | 106    | 49    | 2.80   | 47      | 48    | 30.52  |
| 10 | 106    | 48    | 59.46  | 47      | 48    | 29.96  |
| 11 | 106    | 48    | 54.96  | 47      | 48    | 34.73  |
| 12 | 106    | 48    | 48.79  | 47      | 48    | 35.51  |
| 13 | 106    | 48    | 49.15  | 47      | 48    | 37.61  |
| 14 | 106    | 48    | 56.00  | 47      | 48    | 36.85  |
| 15 | 106    | 48    | 56.83  | 47      | 48    | 39.88  |



Зураг № 1 Төслийн талбайн байршлын зураг

### 1.3. Төслийн хүчин чадал

Тус аялал жуулчлалын цогцолбор нь анх 1992 онд “Цагаан шонхор” холдинг компанийн харьяа “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбор байгуулагдсан бөгөөд одоог хүртэл Богдхан уулын ДЦГ-ын Жаргалантын аманд хүчил төрөгчтэй эрүүл цэвэр агаарт аялал, жуулчлал, рестораны үйл ажиллагааг үндэсний хэв маягтай хослуулан үйл ажиллагаа явуулж байна.

- Монголчууд нүүдэлчин, анчин, малчин ард түмэн тул малынхаа болон ангийн арьс шир, үс ноосоор гэр бараа, хувцас хийж арьсаар нь гоёж чимдэг байсан уламжлалын дагуу гэрүүдийг цэвэр эсгий, модоор хийсэн бөгөөд гэрүүдийн тавилгуудыг модоор урлаж хийсэн.
- Гадна талбайн явган хүний замыг байгалийн унасан чулуу ашиглан хийсэн.
- Эртний монгол ахуй орчныг бүрдүүлэх зорилгоор цогцолборын эргэн тойронд буй орчин үеийн загвар шийдэл бүхий барилга байгууламж, ариун цэврийн байр, агуулах, ариун цэврийн газрын дотор болон гаднах хэсгийг чулуугаар бүрж орчин нөхцөлтэйгөө уялдуулан барьсан.


“Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборын зохион байгуулдаг арга хэмжээ:

- Хурим найр,
- Хүндэтгэлийн хүлээн авалт,
- Өв соёлын цогц үйлчилгээ /морь унах, нум сум харвах, үндэсний урлагийн тоглолт г.м/
- Монгол наадмын цогц арга хэмжээ

- Байгууллага хувь хүмүүсийн тэмдэглэлт ойн баяр,
- Жуулчны байгууллагуудтай хамтран ажилладаг
- Бүргэдийн баяр арга хэмжээ
- Хуралдай наадам гэх мэт олон төрлийн үйлчилгээ үзүүлдгээрээ давуу талтай.
- Том гэр ресторанд монгол үндэсний амт чанартай хоолоор үйлчлүүлэхээр зочид олноороо зорин ирдэг. Учир нь гэр ресторан нь монгол үндэсний хоолыг орчин цагт нийцүүлэн хүргэдэг бөгөөд тэр бүр хийх боломжгүй өвөрмөц хоолнуудыг захиалах боломжтойгоороо онцлогтой.

Стандартын шаардлага хангасан барилга байгууламж, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээтэй. Амрагчдын ая тухыг хангах бүх л зүйлсээр тохижуулсан бөгөөд телевиз, интернэт, халуун, хүйтэн ус, өрөөний үйлчилгээтэй, гэр буудал нь нэг ээлждээ хамгийн ихдээ 226 амрагч, гэр ресторан нь нэг ээлжиндээ зун 1300, өвөл 600 зочид хүлээн авах хүчин чадалтай, жилийн 4 улирал аялал жуулчлал, гэр рестораныг хослуулан үйл ажиллагаа явуулж байна. Мөн сагсны талбай, хүүхдийн тоглоомын талбайтай, хотоос холгүй учир амрагчид цэвэр агаарт хонох болон гэр ресторанаар тав тухтай цагийг зөв боловсон өнгөрөөж үйлчлүүлэх боломжтой байна.

Дэд бүтцийн хувьд хэрэглээний халуун усыг нарны дэлгэц ашиглан халаадаг, төслөөс гарч буй саарал усыг цэвэршүүлэн дахин ашигладаг. Цэвэрлэх байгууламжаас гарсан усаа дахин ашиглаж ариун цэврийн өрөөний суултуур, ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэдэг. Цэвэрлэх байгууламжаас гарсан лагийг компанитай гэрээ байгуулан соруулдаг. Өвлийн улиралд усан халаалтын зуухаар халаадаг. Усан халаалтын зуухнаас гарсан үнсийг хог хаягдлын компаниар тухай бүрт нь ачуулдаг. Төслөөс үүссэн хатуу хог хаягдлыг Хан-Уул дүүргийн засаг дарга болон ХУД-ийн “ХАН-ЭКО ТЭЭВЭР” ААТҮГ-тэй гэрээ байгуулан тогтмол хугацаанд зайлуулдаг байна.



Зураг № 2 Төслийн талбайн агаар сансрын зураг



### **Хүний нөөц**

Тус цогцолбор нь улирлаас шалтгаалан харилцан адилгүй зочид хүлээн авдаг бөгөөд зун 110, өвөл 70 ажилтан ажилладаг.

### **Ажиллах горим**

Баасан гарагаас Ням гараг хүртэл бүх ажилчид ажилладаг ба Даваа гарагаас Пүрэв гараг хүртэл 2 ээлжээр хуваагдан ажилладаг байна.

### **Барилга байгууламж**

Тус цогцолбор нь 108 гэртэй бөгөөд амрагч, жуулчид байрлах боломжтой 1,2,3,4 ортой 4,5,6,8 ханатай 90 гэртэй, нэг ээлжинд зун 1,300, өвөл 600 хүртэл зочид хүлээн авах хүчин чадалтай гэр ресторанууд болон сагсны талбай зэргээс бүрдэнэ.

### **Бага оврын уурын зуух**

Тус аялал жуулчлалын газар нь 1,400 кВт хүчин чадал бүхий хатуу түлшээр ажилладаг ШГ маркийн 1 ширхэг усан халаалтын зуухыг ашигладаг. Жил бүрийн 09 сарын 15-наас 05 дугаар сарын 15-ныг хүртэл халаадаг байна. Уурын зуухны дулаан гаргах чадвар нь 1.204 Гкал/цаг байна.

Усны хэрэглээг төслийн цэвэрлэх байгууламжаас гарч буй саарал уснаас авч ашиглана.

Бага оврын зуухны эргэлтээр ашиглах усыг БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301-р тушаалын 14 дүгээр хавсралтад заасан бага оврын зуухны хэрэглээний нормын аргачлалаар тооцоход 1 Гкал дулаан гаргахад  $2.0 \text{ м}^3$  ус хэрэглэнэ гэж заасан байна.

Тус уурын зуухыг 2021 онд суурилуулсан бөгөөд 2021-2025 оны хугацаанд зуухны нөхөн сэлбэлтийн хувь 3-5 байсан бөгөөд бид хамгийн өндрөөр буюу 5%-иар авч тооцлоо. Тус уурын зуух нь  $1.204 \text{ Ккал/дулаан} * 2.0 \text{ м}^3 * 24 \text{ цаг} = 57.8 \text{ м}^3/\text{хон}$  /1 удаа дүүргэхэд/ ус хэрэглэнэ. Үүний 94 хувийг ( $54.9 \text{ м}^3$ ) байнгын, 5 хувийг ( $2.9 \text{ м}^3$ ) нөхөн сэлбэхээр авч ашиглана. Жилд нөхөн сэлбэлтээр усны хэмжээ  $2.9 * 240$  хоног халаалттай байхад  $751.3 \text{ м}^3$  усыг хэрэглэнэ.

### **Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал**

*Хатуу хог хаягдал:* Уг төсөл нь улирлын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй хүн хүлээж авч, ажилладаг ба үүнийгээ дагаад ажилчид ч харилцан адилгүй байдаг учир улирал тус бүрээр нь тооцож гаргалаа. Гэр буудалд зун 226 амрагч, бусад улиралд 113 амрагч хүлээж авах хүчин чадалтай бол гэр ресторанд зун 1300, бусад улиралд 600 хүн өдөрт хүлээн авах хүчин чадалтай байна. Харин ажилчдын хувьд зун 110 ажилчин бусад улиралд 70 ажилчин ажилладаг байна. 1 хүн 1 хоногт  $0.41 \text{ кг}$  хатуу хог хаягдал ялгаруулдаг гэж үзвэл тус цогцолборт нийт 1 хоногт 1.2 тн, 1 жилд 107.5 тн хатуу хог хаягдал гарах урьдчилсан тооцоо гарсан.

*Хатуу хаягдлыг хадгалах, зайлуулах, устгах:* Хатуу хог хаягдлыг нэгдсэн цэгт хуримтлуулан Хан-Уул дүүргийн 8-р хорооны засаг дарга, Хан-Уул дүүргийн “Хан эко тээвэр” ХХК-тай гэрээ байгуулан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн зайлуулдаг ба цаашид хог хаягдлын гэрээг сунгуулан тогтмол зайлуулах шаардлагатай.

*Шингэн хог хаягдал:* Тус цогцолбороос гарах шингэн хаягдлын хэмжээг унд, ахуйн усны хэрэглээний 70 % гэж үзээд тооцвол ойролцоогоор 1 жилд 7,231.0 м<sup>3</sup> шингэн хаягдал гарна.

*Шингэн хог хаягдлыг хадгалах, зайлуулах, устгах:* Бохир усыг цэвэрлэх байгууламжид хуримтлуулан цэвэршүүлж дахин ашигладаг ба үүссэн лагийг тогтмол

соруулдаг. Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь лаг соруулдаг байгууллагатай гэрээ байгуулан тогтмол хугацаанд соруулж, бохир усны шинжилгээг байх шаардлагатай.

***MBR ахуйн хэрэглээний бохир ус цэвэрлэх байгууламж***

БНХАУ-ын Зун Шин компанийн бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж нь 1 хоногт 70 м<sup>3</sup> хүртэл усыг цэвэршүүлэх хүчин чадалтай ба тус төхөөрөмжийг 2019 оноос эхлэн лабораториор шинжлүүлэн байгальд нөлөөгүй гэж батлагдсан тул зуны улиралд усалгаа болон аялал жуулчлалын газрын ариун цэврийн өрөөний суултуурын усанд дахин ашиглаж байна.

Мөн ариун цэврийн өрөөнүүдээ автомат мэдрэгчтэй цорго суурилуулснаар үр ашиггүй гарах усыг хэмнэж байна.



***Зураг № 3 Ус цэвэршүүлэх үйл явцын дараалал***

Цэвэрлэх байгууламжийн мембран шүүлтүүр нь хоногт 20 м<sup>3</sup>/хон ус шүүх хүчин чадалтай. Мембран шүүлтүүр нь дотроо 12 ширхэгтэй 3 жилд 1 удаа сольдог. Хяналтын самбар нь монгол заавартай. Автомат болон гараар тохируулж болдог.



Зураг № 4 Цэвэрлэх байгууламж

**Зам, гадна талбайн тохижилт:** Тус аялал жуулчлалын цогцолбор нь хурдны замаас 3.5 км зайд байрлана. Мөн ашиглалтын талбайд автомашины зогсоол, гэр хоорондын явган хүний чулуун зам, хогийн сав, гэрэлтүүлэг спортын талбай, хүүхдийн тоглоомын талбай зэргийг төлөвлөж хатуу хучилттай болгон тохижуулсан. Өнгө үзэмж сайтай нэр хаяг бүхий шөнийн гэрэлтүүлэгтэй самбаруудтай.

- Халуун хүйтэн устай саун, душ, 24 цагаар ажилладаг.
- Мөн үйлчлүүлэгчийн тав тух аюулгүй байдлыг хангах зорилгоор цогцолборын орчинд нийт 110 ширхэг бүрэн камержуулалт хийж, гэрүүдийн үүдрүү харсан байдлаар шийдсэн.
- Хамгаалалтын албатай хамтран ажилладаг.
- Шилэн кабельтай холбогдсон ба цогцолборын бүсэд интернет wi-fi ашиглах боломжтой.
- Цагаан хэрэглэл болон даавуу зэргийг хими цэвэрлэгээтэй хамтран ажиллаж угаалгадаг.
- Хэрэглээний бохир усыг шүүж цэвэршүүлэн саарал усыг гарган авч ариун цэврийн өрөөнүүдийн суултуурын ус болон усалгаандаа ашигладаг.



Зураг № 5 Ариун цэврийн өрөө, душ



## ХОЁР.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### *Төслийн газарзүйн байршил:*

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар зүүн, урд, баруун, хойд талаараа тус тус хүрээлэгдсэн бөгөөд Туул, Сэлбэ голуудын бэлчир хөндийд байрладаг. Дунджаар далайн түвшнээс дээш 1,351 м өндөрт оршдог.

### *Газрын гадарга:*

Судалгааны бүс нутагт дунд зэрэг болон нам уулсын, дов гүвээрхэг тэгш гадаргуу ялгагдана. Дунд зэргийн уулын гадаргуу нь районы баруун хэсэг дэх Улаан Хошуу уул болон Шар Чулуут уул юм. Энэ уулс нь 1,223-1,397 м үнэмлэхүй өндөртэй ба харьцангуй өндөршилт нь 100-150 м байдаг. Голчлон доод эрт төрмөлийн настай хурдас тархсан. Энэ нутаг дэвсгэрт намхан уулсын гадаргуу зонхилдог ба энэ нь дунд уулсыг эмжээрлэн хүрээлсэн байдалтайгаар оршино. Үнэмлэхүй өндөр нь 1,092 м. Дов гүвээрхэг гадаргуу нь уулс хоорондын хотгорт болон голын хөндийн хэсэгт тархсан 950-1,000 м-ийн үнэмлэхүй өндөртэй 20 м-ийн харьцангуй өндөршилттэй байдаг.

Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1,450 орчим метрийн үнэмлэхүй өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий  $0-2.6^{\circ}$  (градуст) байна.


### *Улаанбаатар хотын уур амьсгалын горим:*

Улаанбаатар хотын уур амьсгалын горим нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1,950-2,265 м өндөртэй Богд-Хан, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд Туул голын хөндийд байрладаг (Даваадорж. Д, 2020). Ерөнхийдөө өвөл нь удаан (цас их унана), зун нь богино (аагим халуун, хур тунадас ахиухан ордог ч үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар, намар хүчтэй шуургатай өдөр тохиолддог.

Бид Улаанбаатар хотын уур амьсгалыг тодорхойлохдоо далайн түвшнээс дээш 1,300 м-т орших “Улаанбаатар” цаг уурын станцын 1969-2019 оны хоорондох олон жилийн агаарын температур, хур тунадас, салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Улаанбаатар станцын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур  $-0.3^{\circ}\text{C}$  байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд өвлийн улиралд  $-21^{\circ}\text{C}$ , зуны улиралд  $+19.3^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Агаарын температурын жилийн амплитуд дунджаар  $23.7^{\circ}\text{C}$  орчим байна (Зураг 4).

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэлт дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна.




Зураг № 6 Агаарын температур болон хур тунадасны олон жилийн түүхэн өгөгдөл

Хаврын саруудад орох тунадасны хэмжээ аажмаар ихэссээр 5 дугаар сард ихсэж хамгийн их хур тунадас 7 сард 75.1 мм, намар 9 дүгээр сараас хур тунадасны хэмжээ огцом багсаж, 11 дүгээр сараас өвлийн гормондоо шилжиж 1 сард хамгийн бага хур тунадас буюу дунджаар 2.4 мм унадаг байна. Хоногт хэт их бороо орох, өвөл цас их унаж, хавар огцом дулаарах нь гэнэтийн үер болоход хүргэж, хөрсний эвдрэлийг ихэсгэж, зам, харилцаа, барилга, байгууламжид хор хөнөөл учруулдаг. Анхны цас дунджаар 9 дүгээр сарын 3-р 10 хоногт унах бөгөөд 11 дүгээр сарын дундаас цасан бүрхүүл тогтож, 100 орчим хоног цасан бүрхүүлтэй байж 4 дүгээр сарын эхээр цас хайлж, 5 дугаар сарын эхэн гэхэд дуусна. Сүүлчийн цас хожуудаа 5 дугаар сарын дунд арав хоногт ажиглагддаг. Цасны зузаан 2-4 см байх ба зарим хунгарласан газраа хааяа 10-20 см хүрдэг. Цасны нягт 0.16-0.30 г/см<sup>3</sup> байдаг.

Жилийн нийлбэр хур тунадас дунджаар 248 мм унадаг үүнээс дулаан улирлын нийлбэр хур тунадас 220 мм буюу 89%, харин хүйтний улирлын нийлбэр хур тунадас 28мм буюу 11% ноогдох бөгөөд хур тунадасны хэмжээгээр хээрийн бүсэд хамрагддаг болохыг харуулж байна. Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил өвөл, зун (1 ба 8 дугаар сард) хамгийн их, хавар намар (4 ба 10 дугаар сард) хамгийн бага болох ба жилийн дундаж утга нь 58,6% байна.

#### Хөрсөн бүрхэвч:

Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ уулын хар хүрэн хөрс тархжээ.



Зураг № 7 Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураг

### Ургамлан нөмрөг:

Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд улалж-үетэнт, үетэн-шарилжит бүлгэмдэл тархсан байна.

**Зүйлийн баялаг:** Ургамлын зүйлийн баялгийг тодорхойлохдоо нийт талбайн хэмжээнд тархсан ургамлын баялгийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, монгол нэрийг (Грубов, 1982) бүтээлд зааснаар нэрлэв.

**Тусгаг бүрхэц:** Бүлгэмдэл тус бүрийн ургамлын арви-бүрхцийг тодорхойлохдоо Браун-Бланке-гийн аргаар (Раменский, 1938) 1м<sup>2</sup> хэмжээт торыг ашиглан бүлгэмдлийн хэмжээнд сонгож авсан талбай бүрт 3 давталттайгаар арви- бүрхцийг тодорхойлсон.

### Амьтны аймаг:

Богдхан уулын ДЦГ болон Туул голын сав газрын хэмжээнд 10 овгийн 16 зүйл загас, 2 зүйлийн хоёр нутагтан, 7 баг, 18 аймгийн 60 шахам зүйл хөхтөн, 171 зүйл шувуу бүртгэгдсэнээс 5 зүйл загас, 11 зүйл хөхтөн ховордож болзошгүй, 12 зүйл шувуу, нэг зүйл хөхтөн ховор, нэг зүйл шувуу, нэг зүйл хөхтөн нэн ховор ангилалд багтаж байна.

**Шувуу:** Идлэг шонхор, сар, харцага зэрэг шувууд нь голчлон үлийн цагаан оготно болон бусад жижиг мэрэгч хулганаар хооллодог. Бүргэд тарвага, зурам, хулгана зэрэг амьтдыг барьж иддэг. Элээ, хэрээ, шаазгай, улаан хошуу, алагтуу зэрэг шувууд нь дулааны улиралд шавжаар хооллоно. Дээр дурдсан амьтад болон шувууд нь хот суурин, үйлдвэрийн орчим газрын Экологийн тэнцвэрт байдлыг зохицуулж хадгалж байдаг.



## ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Чингисхааны хүрээ” ХХК-ийн дараагийн байгаль орчны үнэлгээ боловсруулах хүртэл хугацааны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОНХ-н сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журмыг баримталсан бөгөөд төслийн онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд багтах нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлуудыг төлөвлөх шаардлагагүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн иргэд, удирдлагад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь багтсан болно.

### ***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго:***

Чингисхааны хүрээ аялал жуулчлалын цогцолбор төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

### ***Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө:***

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төсөл хэрэгжүүлэгчээс заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд төлөвлөв. БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг 90 хувиас дээш биелэлттэйгээр тайлагнаж, тухайн оны 11 сарын 01-ний дотор орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тухайн ондоо багтаан БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад (БОУАӨЯ-нд) хүргүүлж хянуулна.



## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн аялал жуулчлалын цогцолборын төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага эрчимтэй боловч цогцолборын ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, газрын доорх ус болон хөрс, ургамлан бүрхэвч зэрэг бусад дам нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

#### Хүснэгт № 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| №            | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд                                                          | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээ                                                                                                      | Хамрах хүрээ             | Хэмжих нэгж | Нэгжийн өртөг /мян.төг/  | Тоо хэмжээ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж |
|--------------|--------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------------|--------------------------|------------|-----------------------|------------------------------|
| <b>Агаар</b> |                                                                                            |                                                                                                                                                              |                          |             |                          |            |                       |                              |
| 1            | Галлагааны улиралд уурын зуухны яндангаас гарах бохирдуулагч                               | Уурын зуухны янданд уутат шүүлтүүр байрлуулах                                                                                                                | Уурын зуух               |             | 5,000.0                  |            |                       | 2026 он                      |
| 2            | Үнс зэрэг хуурай хог хийсэн агаар бохирдуулах                                              | Үнс хадгалах битүүмжлэл бүхий сав бий болгох, 2-догч түүхий эд байдлаар бусдад нийлүүлэх боломж судлах                                                       | Уурын зуух               |             | Үйл ажиллагааны зардлаар |            |                       | 2026 он                      |
| 3            | Амрагчид болон ажилчдын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт                    | Тээврийн хэрэгслийг үзлэгт тогтмол хамруулах                                                                                                                 | Амрагчид болон ажилчид   |             | Үйл ажиллагааны зардлаар |            |                       | Жил бүр                      |
| <b>Ус</b>    |                                                                                            |                                                                                                                                                              |                          |             |                          |            |                       |                              |
| 4            | Усыг хэтрүүлэн замбараагүй хэрэглэх, дүгнэлтээс хэтэрсэн хэрэглээнээс төлбөр төлөхгүй байх | Тоолуурыг эвдэрсэн тохиолдолд засварлах                                                                                                                      | Гүний худаг              |             | Үйл ажиллагааны зардлаар |            |                       | Тоолуур эвдэрсэн тухай бүр   |
| <b>Хөрс</b>  |                                                                                            |                                                                                                                                                              |                          |             |                          |            |                       |                              |
| 5            | Хөрсний үржил шимт байдал алдагдах, талхлагдах                                             | Барилга байгууламж, гэр барих үедээ үржил шимт хөрсийг хуулах                                                                                                | Гэр, байгууламж ойролцоо |             | Үйл ажиллагааны зардлаар |            |                       | Тухай бүрт                   |
| 6            | Нүүрс, үнсээр бохирдох                                                                     | Ахуйн хог хаягдлын ангилан ялгах сав бий болгох, хашаажуулах<br>Үнс, нүүрс хадгалах савыг битүү болгох                                                       | Нүүрсний агуулах         |             | 1,000.0                  |            |                       | 2026 он                      |
| 7            | Хөрсний бохирдол үүсэх                                                                     | Уутат шүүлтүүр тавьсан тохиолдолд үүссэн лагийг өдөрт 1 удаа цэвэрлэх ба цэвэрлэсэн усанд шохойн чулуун уусмалтай усаар саармагжуулж зайлуулах шаардлагатай. | Уурын зуухын ойролцоо    |             | Үйл ажиллагааны зардлаар |            |                       | Өдөр бүр                     |



| Ургамлан нөмрөг, амьтны аймаг |                                             |                                                                                                                                                             |                                   |                              |            |
|-------------------------------|---------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|------------------------------|------------|
| 8                             | Ургамлан нөмрөг устгах, доройтох            | Ногоон байгууламж бий болгох                                                                                                                                | Төслийн талбайд                   | Тэрбум мод хэсэгт тооцогдсон | 2026 он    |
| 9                             | Зэрлэг амьтад дайжих, хууль бус ан агнуур   | Ажилчид болон амрагч үйлчлүүлэгчид хууль бус ан агнуур хийхгүй байх, хийсэн тохиолдолд хүлээх торгууль хариуцлагын талаар ухуулга сургалт сурталчилгаа хийх | Удирдлага, ажилчид болон амрагчид | Дотоод зохион байгуулалтаар  | Тухай бүр  |
| 10                            | Мод тарьсан талбайд мал, амьтан орж сүйтгэх | Талбайг хашаалж, хаалт хийнэ                                                                                                                                | Мод тарих талбайд                 | 2,000.0                      | 2026 он    |
| Хог хаягдал                   |                                             |                                                                                                                                                             |                                   |                              |            |
| 11                            | Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох          | Ахуйн хог хаягдлын ангилан ялгах сав бий болгох, хашаажуулах Үнс нүүрс хадгалах савыг битүү болгох                                                          | Хогийн цэг, Уурын зуухны орчим    | Дээр төлөвлөгдсөн            | 2026 он    |
| 12                            | Хогийн цэгээс халдвар гарах                 | Хогийн цэг, ариун цэврийн байгууламжид ариутгал халдваргүйжүүлэлт хийх                                                                                      | Хогийн цэг, АЦБ                   | 500.0                        | Улирал бүр |
| 2026 оны зардал               |                                             |                                                                                                                                                             |                                   | 8,500.0                      |            |

#### 4.2. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд 2026-2027 онуудад жил бүр 2,500-3,000 мод тарихаар Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаатай хийсэн гэрээний дагуу мод тарих төлөвлөлтийг доор оруулав(Богдхан уулын ДЦГ-ын захиргаатай хийсэн гэрээг хавсралтаар оруулав).

##### Хүснэгт № 4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

| № | Тарих модны зүйлийн нэр | Нэгжийн үнэ /мян.төг/ | Модны тоо, ш<br>2026 он | Баримтлах стандарт ба аргачлал          |
|---|-------------------------|-----------------------|-------------------------|-----------------------------------------|
| 1 | Хус (50-60 см)          | 5,000.0               | -                       | МУ-ын Ерөнхийлөгчийн А/58 дугаар зарлиг |
| 2 | Гацуур                  | 5,000.0               | 500                     |                                         |
| 3 | Шинэс (40-50 см)        | 5,000.0               | 1,000                   |                                         |
| 4 | Нарс (20-40 см)         | 5,000.0               | 1,000                   |                                         |
|   | Нийт                    |                       | 2,500                   |                                         |
|   | Зардал /мян.төг/        |                       | 6,000.0                 |                                         |



#### 4.3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт № 5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| №     | Хяналтын шинжилгээ хийх үзүүлэлтүүд           | Хэмжих нэгж         | Мониторингийн цэг                                | Хугацаа ба давтамж         | Нэгжийн өртөг | Зардал /мян.төг/<br>2026 он |
|-------|-----------------------------------------------|---------------------|--------------------------------------------------|----------------------------|---------------|-----------------------------|
| Агаар |                                               |                     |                                                  |                            |               |                             |
| 1     | TSP                                           | мкг/м³              | Уурын зуух<br>Зогсоол                            | Хавар, намар /жилд 1 удаа/ | 50.0 * 2 цэг  | 100.0                       |
| 2     | PM <sub>10</sub>                              |                     |                                                  |                            |               |                             |
| 3     | PM <sub>2.5</sub>                             |                     |                                                  |                            |               |                             |
| 4     | NO <sub>2</sub> /азотын давхар исэл           |                     | Уурын зуух<br>Хогийн цэгийн ойролцоо             | Жилд 1 удаа                | 50.0 * 2 цэг  | 100.0                       |
| 5     | Хүхэрлэг хий (SO2)                            |                     |                                                  |                            |               |                             |
| 6     | Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO2), CO, HCN, O2. |                     |                                                  |                            |               |                             |
| Ус    |                                               |                     |                                                  |                            |               |                             |
| 7     | Нийт хатуулаг                                 | Н                   | Ундны ус                                         | Жилд 2 удаа                | 46.0 * 2 цэг  | 92.0                        |
| 8     | Хлорын ион /Cl/                               | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 9     | Сульфатын ион /SO4/                           | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 10    | Натрийн азот (NO <sub>2</sub> <sup>-</sup> )  | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 11    | Нитрат азот (NO <sub>3</sub> <sup>-</sup> )   | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 12    | (CO <sub>3</sub> <sup>-</sup> )               | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 13    | (HCO <sub>3</sub> <sup>-</sup> )              | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 14    | Устөрөгчийн илтгэгч /PH/                      | мг/л                |                                                  |                            |               |                             |
| 15    | Үнэр                                          | Чанарын үнэлгээгээр |                                                  |                            |               |                             |
| 16    | Амт                                           | Чанарын үнэлгээгээр |                                                  |                            |               |                             |
| 17    | Өнгө                                          | Чанарын үнэлгээгээр |                                                  |                            |               |                             |
| 18    | MNS 4943:2015 стандартын үзүүлэлтүүд          | мг/л                | Саарал ус                                        |                            | 46.0 * 2 цэг  | 92.0                        |
| Хөрс  |                                               |                     |                                                  |                            |               |                             |
| 19    | Агрохими                                      | -                   | Гэрүүдийн ойролцоо<br>Уурын зуух<br>Хяналтын цэг | Жилд 1 удаа                | 25.0 * 3 цэг  | 75.0                        |



|      |             |          |                                                                |             |                       |       |
|------|-------------|----------|----------------------------------------------------------------|-------------|-----------------------|-------|
| 20   | Хүнд металл | мг/100гр | Гэрүүдийн ойролцоо<br>Уурын зуух<br>Хогийн сав<br>Хяналтын цэг | Жилд 2 удаа | 30.0 * 4 цэг /2 удаа/ | 240.0 |
| 21   | Эрүүл ахуй  | мг/100гр | Гэрүүдийн ойролцоо<br>Хогийн сав<br>Хяналтын цэг               | Жилд 2 удаа | 25.0 * 3 цэг /2 удаа/ | 150.0 |
| Нийт |             |          |                                                                |             |                       | 849.0 |

#### 4.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тус ажлын хүрээнд галын буланг шинэчлэн сайжруулах шаардлагатай. Мөн ажилчдад ХАБЭА-н болон гамшгийн үеийн сургалтыг зохион байгуулж сургах ажлыг төлөвлөв. Галын булан шинэчлэх ажилд 1,000.0 мян.төгрөг, сургалтын ажилд 1,000.0 мян.төгрөг тус тус төлөвлөв.

##### Хүснэгт № 6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| № | Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл                                                                | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                               | Арга хэмжээний цар хэмжээ | Нэгжийн                | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж         |
|---|----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|------------------------|-----------------------|----------------------------------------|
|   |                                                                                                    |                                                                                                       |                           | Зардал /мян.төг/       |                       |                                        |
| 1 | Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах | Ажилчид                   | 1,000.0                | 1,000.0               | 2 жил тутам                            |
| 2 |                                                                                                    | Галын дохиоллын систем, гал унтраах хэрэгслийг зохих газруудад шинэчлэн байрлуулах                    | Удирдлага                 | 1,000.0                | 1,000.0               | Жил бүр                                |
| 3 |                                                                                                    | Ариун цэврийн байгууламжийг агааржуулагчтай болгох                                                    | Удирдлага                 | Үйл ажиллагааны зардал |                       | 2026 он<br>/Эвдэрсэн тохиолдолд засах/ |
| 4 |                                                                                                    | Зочдын аюулгүй байдлыг хангах үүднээс гар чийдэнгийн нөөцтэй байна.                                   | Удирдлага                 | Үйл ажиллагааны зардал |                       | Тогтмол                                |
| 5 |                                                                                                    | Ариутгал халдваргүйжүүлэлт хийх                                                                       | Ажилчид                   | Үйл ажиллагааны зардал |                       | Тогтмол                                |



|      |  |                                         |         |                        |         |
|------|--|-----------------------------------------|---------|------------------------|---------|
| 6    |  | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Ажилчид | Үйл ажиллагааны зардал | Жил бүр |
| Нийт |  |                                         |         | 2,000.0                |         |

#### 4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

##### Хүснэгт № 7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө   | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                          | Арга хэмжээний цар хэмжээ | Нэгжийн          | Нийт зардал /мян.төг/  | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|--------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|------------------|------------------------|--------------------------------|---------------------------------|
|   |                                            |                                                                                                                                                  |                           | Зардал /мян.төг/ |                        |                                |                                 |
| 1 | Удирдлагын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Удирдлага                 |                  | Үйл ажиллагааны зардал | Жил бүр                        | MNS 5002:2000                   |

#### 4.6. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

##### Хүснэгт № 8 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

| № | БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд                                         | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр   | Мэдээний агуулга                                       | Хугацааны тов  |
|---|------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|--------------------------------------------------------|----------------|
| 1 | Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 8-р хорооны иргэд, байгаль хамгаалагч, байгаль орчны ажилтан | Уулзалт, санал асуулга          | БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах | 10-11-р сар    |
| 2 | Нийслэлийн БОГ-т тайлангаа хүргүүлэх                                                           | Тайлангийн эх хувь, албан бичиг | Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх, Дүгнүүлэх        | 11.01<br>12.31 |
| 3 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам                                                   | Тайлангаа баталгаажуулах        | Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн талаар              | 12.31          |



#### 4.7. БОМТ-ний зардлын нэгтгэл

##### Хүснэгт № 9 БОМТ-ний нийт зардал

| №               | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                  | 2026 он /мян.төг/ |
|-----------------|------------------------------------------------------------------------------------------|-------------------|
| 1               | Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө                                              | 8,500.0           |
| 2               | Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих                                                 | 6,000.0           |
| 3               | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр                                                       | 849.0             |
| 4               | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө                                                   | 2,000.0           |
| 5               | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө                                                 | ҮА-ны зардлаар    |
| 6               | БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | -                 |
| 2026 оны зардал |                                                                                          | 17,349.0          |

#### ДҮГНЭЛТ

“Чингисхааны хүрээ” ХХК-ийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 8-р хорооны нутагт хэрэгжих аялал жуулчлалын цогцолборын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийж гүйцэтгэлээ.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 онд нийт 17,349.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.